



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/37/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын Ерөнхий аудитормын

Орлогч: Я.Самбууням

Утас: 51-261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Санхүү, нийцлийн газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхбаатар

Утас: 51-260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ

Утас: 51-261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn

Аудитор: П.Ариунзаяа

Утас: 51-261628 Цахим хаяг: Ariunzayap@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.25 № 1617
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудлыг нэмж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 онд шинээр батлагдаж, уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашгийг баялгийн санд төвлөрүүлэхээр хуульчилсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж хүргүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,656,896.6	137,577,992.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,070,267.1	59,612,359.5
33	АВЛАГА	3,063,620.2	7,575,389.7
34	УРЬДЧИЛГАА	2,044,183.0	30,037,957.1
35	БАРАА МАТЕРИАЛ	25,801,491.4	37,614,981.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,677,334.9	2,737,304.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	280,126,549.0	320,581,067.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	280,126,549.0	320,581,067.0
39200	Биет хөрөнгө	223,381,332.5	271,100,786.7
39300	Биет бус хөрөнгө	56,745,216.5	49,480,280.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	345,783,445.6	458,159,059.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,210,566.4	24,588,950.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	916,206.0	24,341,359.2
41300	Өглөг	467,936.7	23,756,135.3
41400	Урьдчилж орсон орлого	448,269.4	585,224.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	294,360.4	247,590.8
42200	Урт хугацаат зээл	294,360.4	247,590.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	344,572,879.2	433,570,109.7
51	Засгийн газрын хувь оролцоо	344,572,879.2	433,570,109.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	32,737,729.3	41,798,168.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	104,537.4	104,537.4
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	2,175,079.3	2,175,079.3
51200	Хуримтлагдсан үр дүн	298,067,522.8	378,070,693.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,488,010.3	11,421,630.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	345,783,445.6	458,159,059.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	703,661,344.9	866,790,554.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	473,887,171.5	83,324,347.0
120	Нийтлэг татварын бус орлого	473,001,293.4	83,307,167.1
121	Хөрөнгийн орлого	872,533.4	-
122	Тусламжийн орлого	13,344.8	17,179.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,774,173.3	783,466,207.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	649,636,966.5	760,524,441.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	649,400,763.1	736,787,545.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	190,329,848.7	708,067,099.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	78,524,766.4	160,039,620.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,333,837.2	7,575,166.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,541.0	1,133,853.8
2104	Хангамж, бараа материалын зардал	157,252.9	1,638,764.6
2105	Нормативт зардал	-	22,728.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	497,494.8
2107	Томилолт, зочны зардал	148,586.3	1,170,721.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,323,229.8	408,966,801.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,760,635.2	127,021,947.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	459,070,914.4	28,720,445.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	236,203.4	23,736,896.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	54,024,378.3	106,266,112.6
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	475.9	277.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	176,702,235.1	1,589,562.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(122,677,380.8)	104,676,826.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	593,752,035.1	-	593,752,035.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(127,953,994.8)	-	(127,953,994.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	465,798,040.3	-	465,798,040.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	722,203.0	-	722,203.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	730,016.7	-	730,016.7
9	Тайлант үеийн үр дүн	(122,677,380.8)	-	(122,677,380.8)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,572,879.2	-	344,572,879.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(14,814,491.3)	-	(14,814,491.3)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	329,758,387.8	-	329,758,387.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(910,579.1)	-	(910,579.1)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	45,474.0	-	45,474.0
19	Тайлант үеийн үр дүн	104,676,826.9	-	104,676,826.9
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,570,109.7	-	433,570,109.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	707,096,500.6	844,053,202.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	475,806,467.3	57,734,761.9
120	Нийтлэг татварын бус орлого	474,933,934.0	57,734,761.9
121	Хөрөнгийн орлого	872,533.4	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	231,290,033.3	786,318,440.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	604,536,593.0	287,829,768.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	604,536,593.0	287,829,768.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,078,762.5	263,000,643.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	84,230,285.1	171,309,864.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,917,833.5	9,316,386.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245,833.4	1,234,812.4
2104	Хангамж, бараа материалын зардал	645,581.2	1,521,915.5
2105	Нормативт зардал	-	9,875.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,954.7	660,243.8
2107	Томилолт, зочны зардал	489,015.8	1,635,140.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,645,859.6	12,441,215.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,822,399.3	64,871,190.0
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	457,457,830.4	24,829,125.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	102,559,907.7	556,223,433.5
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	2,483.7	4,005.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	105,692,084.8	529,684,494.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	105,692,084.8	529,684,494.0
2200	Дотоод эх үүсвэрээр	105,692,084.8	529,684,494.0
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(105,689,601.1)	(529,680,488.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(372.4)	(852.2)
14	Бусад эх үүсвэр	475.9	256.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	848.3	1,108.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(3,130,065.8)	26,542,092.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,200,333.0	33,070,267.1

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,070,267.1	59,612,359.5
----	---	--------------	--------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	384,831,732,400.00	362,520,625,229.51	22,311,107,170.49	94.2
УРСГАЛ ЗАРДАЛ	311,552,273,800.00	290,788,121,135.79	20,764,152,664.21	93.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308,714,961,700.00	288,125,763,504.09	20,589,198,195.91	93.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	166,569,648,800.00	158,337,031,032.08	8,232,617,767.92	95.1
Үндсэн цалин	17,543,154,000.00	16,914,380,270.04	628,773,729.96	96.4
Нэмэгдэл	137,922,799,500.00	132,552,307,984.71	5,370,491,515.29	96.1
Унаа хоолны хөнгөлөлт	9,805,426,900.00	6,546,802,374.07	3,258,624,525.93	66.8
Урамшуулал	1,298,268,400.00	2,323,540,403.26	(1,025,272,003.26)	179.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,301,168,900.00	7,027,495,162.00	273,673,738.00	96.3
Тэтгэврийн даатгал	3,643,342,900.00	5,123,452,483.50	(1,480,109,583.50)	140.6
Тэтгэмжийн даатгал	392,911,800.00	343,778,429.49	49,133,370.51	87.5
ҮОМШӨ-ний даатгал	195,249,900.00	176,708,775.67	18,541,124.33	90.5
Ажилгүйдлийн даатгал	197,435,600.00	171,508,226.66	25,927,373.34	86.9
Эрүүл мэндийн даатгал	2,872,228,700.00	1,212,047,246.68	1,660,181,453.32	42.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	878,941,100.00	860,346,452.11	18,594,647.89	97.9
Гэрэл, цахилгаан	72,679,300.00	72,812,006.67	(132,706.67)	100.2
Түлш, халаалт	356,895,700.00	353,071,178.14	3,824,521.86	98.9
Цэвэр, бохир ус	56,650,600.00	46,776,100.80	9,874,499.20	82.6
Байрны түрээс	392,715,500.00	387,687,166.50	5,028,333.50	98.7
Хангамж, бараа материалын зардал	275,530,100.00	268,977,751.60	6,552,348.40	97.6
Бичиг хэрэг	76,638,500.00	77,983,404.00	(1,344,904.00)	101.8
Тээвэр, шатахуун	109,547,600.00	99,860,044.00	9,687,556.00	91.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64,361,500.00	67,025,232.60	(2,663,732.60)	104.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	234,400.00	481,000.00	(246,600.00)	205.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,748,100.00	23,628,071.00	1,120,029.00	95.5
Нормативт зардал	2,246,900.00	1,043,046.00	1,203,854.00	46.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,246,900.00	1,043,046.00	1,203,854.00	46.4
Эд хогшил, урсгал засварын зардал	765,368,800.00	759,760,662.00	5,608,138.00	99.3
Багаж, техник, хэрэгсэл	648,521,100.00	645,632,409.40	2,888,690.60	99.6
Урсгал засвар	116,847,700.00	114,128,252.60	2,719,447.40	97.7
Томилолт, зочны зардал	482,750,400.00	467,156,497.40	15,593,902.60	96.8
Гадаад албан томилолт	207,355,900.00	203,665,285.40	3,690,614.60	98.2
Дотоод албан томилолт	275,394,500.00	263,491,212.00	11,903,288.00	95.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,206,911,400.00	5,886,414,509.22	320,496,890.78	94.8

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,982,206,600.00	5,667,847,497.56	314,359,102.44	94.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,666,700.00	1,433,100.00	2,233,600.00	39.1
Даатгалын үйлчилгээ	5,384,600.00	4,289,433.00	1,095,167.00	79.7
Тээврийн хэрэгслийн татвар	1,277,900.00	736,521.60	541,378.40	57.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	519,400.00	252,600.00	266,800.00	48.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	51,730,800.00	50,030,323.06	1,700,476.94	96.7
Газрын төлбөр	470,700.00	460,184.00	10,516.00	97.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	161,654,700.00	161,364,850.00	289,850.00	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	126,232,395,300.00	114,517,538,391.68	11,714,856,908.32	90.7
Бараа үйлчилгээний бусад зардал	126,208,168,300.00	114,493,329,691.68	11,714,838,608.32	90.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,227,000.00	24,208,700.00	18,300.00	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,837,312,100.00	2,662,357,631.70	174,954,468.30	93.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,575,700.00	0.00	1,575,700.00	0.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,575,700.00	0.00	1,575,700.00	0.0
Бусад урсгал шилжүүлэг	2,835,736,400.00	2,662,357,631.70	173,378,768.30	93.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	175,438,100.00	172,444,562.00	2,993,538.00	98.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	353,387,400.00	227,766,759.00	125,620,641.00	64.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,255,857,700.00	2,213,212,185.70	42,645,514.30	98.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,053,200.00	48,934,125.00	2,119,075.00	95.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	73,279,458,600.00	71,732,504,093.72	1,546,954,506.28	97.9
Барилга байгууламж	1,200,000,000.00	1,059,970,000.00	140,030,000.00	88.3
Бусад хөрөнгө	72,079,458,600.00	70,672,534,093.72	1,406,924,506.28	98.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	384,831,732,400.00	362,698,375,872.17	22,133,356,527.83	94.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	380,402,572,200.00	357,680,337,183.90	22,722,235,016.10	94.0
Улсын төсвөөс санхүүжих	380,402,572,200.00	357,680,337,183.90	22,722,235,016.10	94.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,429,160,200.00	5,018,038,688.27	(588,878,488.27)	113.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,054,000,000.00	2,705,998,702.74	348,001,297.26	88.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,375,160,200.00	2,312,039,985.53	(936,879,785.53)	168.1
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,439	2,247	192	92.1
БАЙГУУЛЛАГЫН ТОО	19	19	0	100.0
Төсвийн байгууллага	19	19	0	100.0

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

АЖИЛЛАГСДЫН ТОО	1,210	1,114	96	92.1
Удирдах ажилтан	27	26	1	96.3
Гүйцэтгэх ажилтан	1,080	985	95	91.2
Үйлчлэх ажилтан	103	103	0	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,210	1,114	96	92.1
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,046	950	96	90.8
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	164	164	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		15,336,044.3
УРСГАЛ ЗАРДАЛ		14,515,137.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		12,760,194.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,303,098.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		324,847.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		180,575.7
Хангамж, бараа материалын зардал		580,534.3
Нормативт зардал		8,840.0
Эд хогшил, урсгал засварын зардал		758,283.0
Томилолт, зочны зардал		709,086.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,926,420.3
Бараа үйлчилгээний бусад зардал		4,968,509.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,754,942.4
Бусад урсгал шилжүүлэг		167,170.6
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,587,771.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		820,907.3
Дотоод эх үүсвэрээр		820,907.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		15,336,044.3
Нэмэлт санхүүжилтийн орлого		15,336,044.3

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 51,881.1 сая төгрөгийн 46 алдаа¹ илэрснээс аудитын явцад бүрэн залруулсан.

Аудитаар нийт 4,589.2 сая төгрөгийн 98 зөрчил² илэрснээс, 39.7 сая төгрөгийн 13 төлбөрийн акт тогтоож, 1,530.1 сая төгрөгийн 38 албан шаардлага, 3,019.5 сая төгрөгийн 47 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4,589.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,078.7 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 30 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 25 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан.

Аудитаар харьяа байгууллагуудын 23 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Архангай аймгийн ГХБХБГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

3.2 Түүврийн байгууллагууд

3.2.1 Албан шаардлага

1. ЖҮХАА-ны жилийн эцсийн санхүүгийн тайланд 0.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаагүй, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. ЖҮХАА нь урсгал зардлаас 5.1 сая төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. ЖҮХАА нь тайлант онд нэр бүхий 9 иргэнтэй 14.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулснаас хуульд заасан хувь хэмжээгээр ХХОАТ-ыг суутган тооцож, 1.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн дагуу холбогдох татварыг суутган тооцож, үнэн зөв тайлагнаагүй, төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. ЭХЗХ-ны санхүүгийн тайлангаар өмнөх оноос шилжин ирсэн 153.1 сая төгрөгийн, тайлант хугацаанд шинээр үүссэн 64.3 сая төгрөгийн, нийт 217.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Эрчим хүчний зохицуулах хорооны хөдөлмөрийн дотоод журмын 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиргаа нь ... өр авлагыг барагдуулах, ... зэрэг ажлуудыг хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй, авлага үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, өмнөх оноос шилжин ирсэн авлагын 30.0-аас доошгүй хувиар барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

3.2.2 Зөвлөмж

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт: ЖҮХАА нь төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу үндэслэлтэй төлөвлөж батлуулаагүйгээс бараа үйлчилгээний бусад зардлаас гадаад томилолтын зардалд 7.0 сая төгрөг зөвлөх үйлчилгээний зардалд 1.5 сая төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 42.3.1-д "төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийг үндэслэлтэй төлөвлөж дээд шатны төсөв захирагчид хүргүүлж байх.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: ЭХЗХ нь мөнгөн гүйлгээний тайланд сургалт, шуудангийн төлбөрт төлсөн 22.2 сая төгрөгийн зарлагыг Бараа материал худалдан авахад төлсөн зарлагаар буруу ангилж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.9-т "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцээгүй, ангилал ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн гүйлгээний тайланд зарлагын ангиллыг үнэн зөв бүртгэж, толилуулж байх.

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн асуудлаар нийт 11,557.4 сая төгрөгийн 22 зөрчил илрүүлснээс 20.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,733.1 сая төгрөгийн 9 албан шаардлага, 2 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 7,803.6 сая төгрөгийн 9 зөвлөмж өгсөн байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд шилэн дансны цахим хуудсанд байршуулах 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 6,566.6 сая төгрөгийн 8 зөрчил илэрч, 3,702.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2,864.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. МУЕС-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн 4,589.2 сая төгрөг, нийцлийн аудитын асуудлаар 11,557.4 сая төгрөг, нийт 16,146.6 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19 дүгээр зүйлийн 19.1-д "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрч буй алдаа, зөрчлийг бууруулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгаж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг 30.0 хувиар бууруулах албан шаардлага хүргүүлэв.

2. ЖҮХАА нь төсвийн захирагч нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуульд заасан хугацаанаас хоцроож Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. ЖҮХАА нь хуульд заасан шаардлагын хүрээнд жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй, 12 хуулийн этгээдтэй 47.2 сая төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулж дээд шатны төсөв захирагчид хүргүүлээгүй, төлөвлөгдөөгүй худалдан авалтыг гүйцэтгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. ЭХЗХ нь "Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны зорилтот" түвшинг төлөвлөж, батлахдаа төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашгийн хэмжээг төлөвлөөгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т "Зорилтын саналд ирэх 3 жилд эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон дараах зүйлийг тусгана:", 21.2.5-т "төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зорилтын саналд төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашгийн хэмжээг тусгаж, хорооны хурлаар хэлэлцүүлж байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл болон худалдан авах ажиллагаа зэрэг нийцлийн асуудал нь Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

5.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	2	44,195.3			2	44,195.3	2	44,195.3				
2	Харилцаа холбооны зохицуулах хороо	1	2.8	1	2.8			1	2.8				
3	Жендерийн үндэсний хороо Ажлын алба	2	45.2			2	45.2	2	45.2				
4	Бусад байгууллага	3	4,756.1			3	4,756.1	3	4,756.1				
5	Бусад байгууллага	1	188.4			1	188.4	1	188.4				
6	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	3	552.5			3	552.5	3	552.5				
7	Баян-Өлгий аймгийн ГХБХБГ	3	1,318.8	1	0.5	2	1,318.2	3	1,318.8				
8	Булган аймгийн ГХБХБГ	1	205.0			1	205.0	1	205.0				
9	Говь-Алтай аймгийн ГХБХБГ	3	131.9			3	131.9	3	131.9				
10	Говьсүмбэр аймгийн ГХБХБГ	2	1.1			2	1.1	2	1.1				
11	Дархан-Уул аймгийн ГХБХБГ	4	100.3			4	100.3	4	100.3				
12	Дундговь аймгийн ГХБХБГ	2	28.3			2	28.3	2	28.3				
13	Орхон аймгийн ГХБХБГ	1	0.0			1	0.0	1	0.0				
14	Өмнөговь аймгийн ГХБХБГ	4	6.3			4	6.3	4	6.3				
15	Сэлэнгэ аймгийн ГХБХБГ	2	2.2			2	2.2	2	2.2				
16	Төв аймгийн ГХБХБГ	3	10.4			3	10.4	3	10.4				
17	Увс аймгийн ГХБХБГ	1	96.0			1	96.0	1	96.0				
18	Хөвсгөл аймгийн ГХБХБГ	2	16.2			2	16.2	2	16.2				
19	Хэнтий аймгийн ГХБХБГ	4	33.2			4	33.2	4	33.2				

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

20	Нийслэлийн ГЗБА	2	191.2			2	191.2	2	191.2				
Нийт дүн		46	51,881.1	2	3.3	44	51,877.8	46	51,881.1	-	-	-	-

5.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл										
		Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	6	1,741.7			4	47.2	2	1,694.5			
2	Харилцаа холбооны зохицуулах хороо	3	152.9			2	152.9	1	-			
3	Жендерийн үндэсний хороо Ажлын алба	4	15.8			3	7.3	1	8.5			
4	Эрчим хүчний зохицуулах хороо	2	239.4			1	217.4	1	22.0			
5	Бусад байгууллага	4	206.7					4	206.7			
6	Бусад байгууллага	12	640.4	1	2.0	1	15.5	10	622.9			
7	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга	1	524.3			1	524.3					
8	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	6	365.3	1	7.6	2	346.4	3	11.3			
9	Архангай аймгийн ГХБХБГ	4	17.3			4	17.3					
10	Баян-Өлгий аймгийн ГХБХБГ	3	62.1	1	3.8	2	58.2					
11	Баянхонгор аймгийн ГХБХБГ	2	1.0	2	1.0							
12	Булган аймгийн ГХБХБГ	2	11.0			1	1.8	1	9.3			
13	Говь-Алтай аймгийн ГХБХБГ	6	24.6	1	0.6	4	24.0	1	-			
14	Говьсүмбэр аймгийн ГХБХБГ	2	3.0			1	1.7	1	1.3			
15	Дархан-Уул аймгийн ГХБХБГ	1	0.6	1	0.6							
16	Дорноговь аймгийн ГХБХБГ	2	4.0					2	4.0			
17	Дорнод аймгийн ГХБХБГ	1	3.2	1	3.2							
18	Дундговь аймгийн ГХБХБГ	4	3.6			3	2.1	1	1.5			

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

19	Завхан аймгийн ГХБХБГ	5	22.9	3	11.1	1	2.9	1	8.9			
20	Орхон аймгийн ГХБХБГ	3	11.7			1	11.7	2	-			
21	Өмнөговь аймгийн ГХБХБГ	1	1.5					1	1.5			
22	Сүхбаатар аймгийн ГХБХБГ	5	2.9			1	2.9	4	-			
23	Сэлэнгэ аймгийн ГХБХБГ	3	11.0	1	0.2	2	10.9					
24	Төв аймгийн ГХБХБГ	7	24.5			3	24.5	4	-			
25	Ховд аймгийн ГХБХБГ	3	29.7	1	9.7			2	20.0			
26	Хөвсгөл аймгийн ГХБХБГ	2	80.0					2	80.0			
27	Нийслэлийн ГЗБА	4	388.0			1	60.9	3	327.1			
Нийт дүн		98	4,589.2	13	39.7	38	1,530.1	47	3,019.5			

5.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	1	3,323.0			1	3,323.0					
2	Бусад байгууллага	1	-					1	-			
3	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	1	386.1					1	386.1			
4	Баянхонгор аймгийн ГХБХБГ	1	24.2			1	24.2					
5	Дархан-Уул аймгийн ГХБХБГ	1	2,478.3					1	2,478.3			
6	Дундговь аймгийн ГХБХБГ	1	-					1	-			
7	Сүхбаатар аймгийн ГХБХБГ	1	-					1	-			
8	Увс аймгийн ГХБХБГ	1	355.0			1	355.0					

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Дүн		8	6,566.6	0	-	3	3,702.3	5	2,864.4			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
1	Монгол Улсын Ерөнхий сайд	1	-			1	-					
2	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	5	4,990.8	1	20.7	3	30.8	1	4,939.2			
3	Жендерийн үндэсний хороо Ажлын алба	2	-			1	-			1	-	1
4	Эрчим хүчний зохицуулах хороо	1	-			1	-					
5	Бусад байгууллага	1	-					1	-			
6	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга	1	-							1	-	1
7	Булган аймгийн ГХБХБГ	1	-			1	-					
8	Говьсүмбэр аймгийн ГХБХБГ	2	-					2	-			
Дүн		14	4,990.8	1	20.7	7	30.8	4	4,939.2	2	-	2
Нийт дүн		22	11,557.4	1	20.7	10	3,733.1	9	7,803.6	2	-	2